



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/06

Шивээговь сум

Газар ашиглах эрхийг хүчингүй болгох тухай ▢

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, 39.1.4, 40 дүгээр зүйлийн 40.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. “Мандал-Сансар” хоршооны гишүүдийн нөөц бэлчээрийн зориулалтаар 2 жилийн хугацаанд газар ашиглах эрхээр авсан газрын газар ашиглах хугацаа дуусч сунгуулах хүсэлт гаргаагүй тул газар ашиглах эрхийг хавсралтад заасны дагуу хүчингүй болгосугай.

2. Газар ашиглах эрхийг дуусгавар болгосныг “Мандал-Сансар” хоршооны гишүүдэд мэдэгдэж, холбогдох бичиг баримтыг хүлээж авахыг Газрын даамал /Т.Өлзийбуд/-д үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2005 оны 01 сарын 16-ний 01 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



Ч.СУГАРМАА



Сумын Засаг даргын 2025 оны
...01... сарын ...15... ны өдрийн
А/06... дугаар захирамжийн хавсралт

ХҮЧИНГҮЙ БОЛГОЖ БУЙ “МАНДАЛ-САНСАР” ХОРШООНЫ ГАЗРУУДЫН БАЙРШИЛ

Д/Д	Овог, нэр	Байршил	Талбайн хэмжээ /м2/
1	С.Манжир	Сэвхүүлийн дов	2.5 га
2	Н.Нацагдорж	Нүхэн сондуул	2 га
3	Н.Раднаабазар	Хөх дэрс	1 га
4	М.Жамсран	Сэвхүүлийн говь	4 га
			9.5 га